

ЗАГВАР 10: АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Найрамдал- Дархан хотын нийгэм эдийн засгийн шинэлэг, тэгш хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжин Европын холбоо-Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх төслийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2023/137/НА-СТА-ТНХ

Цахим хуудас: www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудитор: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: **Б.Алтанзул**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: Altanzulby@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 8.1, Европын холбоо болон Дархан-Уул аймгийн Засаг даргатай байгуулсан CSO-LA/2021/428-390 дугаартай гэрээний 6, 7 дугаар хавсралт, Дархан-Уул аймгийн ЗДТГ-тай байгуулсан "Санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх гэрээ"-ний 1 дүгээр зүйлийн 1.2-д заасны дагуу "Найрамдал-Дархан хотын нийгэм эдийн засгийн шинэлэг, тэгш хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжин Европын холбоо-Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх төсөл"-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Европын холбооны буцалтгүй тусламжийн хүрээнд хийгдсэн гэрээнд заасны дагуу Найрамдал төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ӨС зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Европын холбоо болон Дархан-Уул аймгийн Засаг даргатай байгуулсан CSO-LA/2021/428-390 дугаартай гэрээний дагуу Европын холбооноос буцалтгүй тусламжийн эхний жилийн 1,896,855.7 мянган төгрөгөөс санхүүжилтийг хүлээн авсан.

Аудитын гол асуудал

Тайлант онд бус нутгийг хөгжүүлэх Дархан-Европын форумыг байгуулж, нийгэм эдийн засгийн чөлөөлөөр форум хэлэлцүүлэг, туршлага судлах айлчлал, бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулж, гарааны хөрөнгө оруулалтаар 3 өм ахуйн нэгжид гэрээнд заасны дагуу эхний санхүүжилт болох 27.2 мянган евро буюу 89,262.0 мянган төгрөгийг олгоод байна.

009070793

Бусад асуудлын хэсэг

Найрамдал төслийг хэрэгжүүлэхэд Дархан-Уул аймагт 13, Зүүн өмнөд европын Хойд Македон улсад 3, нийт 16 ажлын байрыг бий болгож, "Европ-Дарханы инноваци, энтрепренершип төв"-ийг шинээр байгуулсан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Европын холбооны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа "Найрамдал төсөл"-ийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/Төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	=	92,557,601.58
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	92,557,601.58
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	92,557,601.58
3122	Гадаад валютаар	-	92,557,601.58
31223	Арилжааны банкин дахь харилцах	-	92,557,601.58
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	=	92,557,601.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	=	92,557,601.58
51	Засгийн газрын хувь оролцоо	-	92,557,601.58
512	Хуримтлагдсан үр дүн	-	92,557,601.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	92,557,601.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	=	92,557,601.58

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	-	1,898,855,783.64
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,898,855,783.64
	Нийтлэг татварын бус орлого	-	1,898,855,783.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,898,855,783.64
1200045	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	1,898,855,783.64
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	1,797,408,010.14
	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,797,408,010.14
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,797,408,010.14
	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ	-	1,797,408,010.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,797,408,010.14
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1-2)	-	101,447,773.47
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	8,890,171.89
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	8,890,171.89
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4)-(5)	-	(8,890,171.89)
	НИЙТ ҮР ДҮН (7)=(3)+(6)	=	92,557,601.58

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-	
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	92,557,601.58	-	-
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	92,557,601.58	-	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	1,898,855,783.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,898,855,783.64
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,898,855,783.64
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1,898,855,783.64
120044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	1,898,855,783.64
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	1,797,408,010.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,797,408,010.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,797,408,010.17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,797,408,010.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,797,408,010.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	101,447,773.47
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	=	8,890,171.89
25001	Гадаад валютын ханшийн зөрүү	-	8,890,171.89
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	(8,890,171.89)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	92,557,601.58
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	92,557,601.58

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар дараах зөрчил¹ илэрсэнд зөвлөмж өгсөн. ХААИС-ийн Агроэкологийн бизнесийн сургуулийн хувьд төслийн санхүүжилтийн орлого, зарлагын гүйлгээг сургуулийн харилцах дантай цуг бүртгэсэн мөн төслийн хөрөнгийн санхүүжилтийн хөрөнгийн валютыг хөрвүүлэхдээ гүйлгээ гарсан тухай бүрд нь бус бөөн дүнгээр хөрвүүлсэн зэрэг зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

1.1 ХААИС-ийн Агроэкологийн бизнесийн сургуулийн хувьд төслийн санхүүжилтийн орлого, зарлагын гүйлгээг сургуулийн харилцах дантай цуг бүртгэсэн нь Европын холбоо Дархан-Уул аймгийн Засаг даргатай байгуулсан Найрамдал төслийн CSO-LA/2021/428-390 дугаартай гэрээний 2 дугаар хавсралтын 16 дугаар зүйлийн 16.1.в дэх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төслийн санхүүжилтийн гүйлгээг сургуулийн харилцах данснаас салгаж бүртгэх

1.2 ХААИС-ийн Агроэкологийн бизнесийн сургууль нь төслийн хөрөнгийн санхүүжилтийн хөрөнгийн валютыг хөрвүүлэхдээ гүйлгээ гарсан тухай бүрд нь бус бөөн дүнгээр хөрвүүлсэн нь Европын холбоо Дархан-Уул аймгийн Засаг даргатай байгуулсан Найрамдал төслийн CSO-LA/2021/428-390 дугаартай гэрээний 2 дугаар хавсралтын 15.9, 15.10 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төслийн санхүүжилтийг зарлагын гүйлгээ гарах үеийн ханшаар хөрвүүлж, бүртгэлд тусган тайлагнах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХААИС-ын Агроэкологийн бизнесийн сургуулийн хувьд төслийн санхүүжилтийн орлого, зарлагын гүйлгээг сургуулийн харилцах данстай цуг бүртгэсэн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
ХААИС-ийн Агроэкологийн бизнесийн сургууль нь төслийн хөрөнгийн санхүүжилтийн хөрөнгийн валютыг хөрвүүлэхдээ гүйлгээ гарсан тухай бүрд нь бус бөөн дүнгээр хөрвүүлсэн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	-	-	-	-	-	-	-	-
2	Төсөл, хөтөлбөр	1	1	-	-	1	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-